



УВС АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/089/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох

Утас: 99454700, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

**ТҮРГЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.БАТСҮХ ТАНАА**

2026.02.10 № УВА-2026/089/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050091

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>311,580,389.61</u>	<u>227,642,326.52</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	203,663,997.59	97,122,509.78
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	203,663,997.59	97,122,509.78
3121	Төгрөг	203,663,997.59	97,122,509.78
31211	Төрийн сангийн харилцах	203,663,997.59	97,122,509.78
33	АВЛАГА	00.00	878,530.00
335	Бусад авлага	00.00	878,530.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	878,530.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,916,392.02	129,641,286.74
351	Түүхий эд материал	136,700.00	110,960.00
35130	Эм боох материал	136,700.00	110,960.00
354	Хангамжийн материал	107,779,692.02	129,530,326.74
35410	Бичиг хэргийн материал	1,719,949.00	3,336,511.00
35420	Аж ахуйн материал	89,715,771.32	107,728,892.32
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	280,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,740,000.00	6,120,000.00
35460	Хүнсний материал	887,276.00	1,684,233.60
35470	Бусад хангамжийн материал	5,716,695.70	10,380,689.82
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,748,707,018.93</u>	<u>3,869,882,706.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,748,707,018.93	3,869,882,706.84
392	Биет хөрөнгө	3,616,629,018.93	3,737,804,706.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,870,400,745.40	4,042,696,485.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-469,181,439.55	-552,034,823.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,000,000.00	34,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,930,555.37	-21,597,222.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	324,898,478.00	375,667,565.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-200,265,644.43	-212,831,283.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,930,046.72	125,630,689.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,310,369.44	-77,022,461.80
39217	Ном	23,087,757.60	23,295,757.60
393	Биет бус хөрөнгө	132,078,000.00	132,078,000.00
39301	Програм хангамж	1,040,000.00	1,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,040,000.00	-1,040,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	132,078,000.00	132,078,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,060,287,408.54</u>	<u>4,097,525,033.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>27,294,500.00</u>	<u>701,100.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	27,294,500.00	701,100.00
413	Өглөг	27,294,500.00	701,100.00
4136	Бусад өглөг	27,294,500.00	701,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	27,294,500.00	701,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,032,992,908.54</u>	<u>4,096,823,933.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,032,992,908.54	4,096,823,933.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	930,072,547.50	930,072,547.50
51101	Өмч: - төрийн	930,072,547.50	930,072,547.50
512	Хуримтлагдсан үр дүн	2,688,373,618.56	2,752,204,643.38
51210	Өмнөх үеийн үр дүн	2,688,373,618.56	2,688,373,618.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	63,831,024.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	414,546,742.48	414,546,742.48

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,060,287,408.54	4,097,525,033.36
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,659,309,101.00	1,775,076,960.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,746,001.00	294,854,660.96
120	Нийтлэг татварын бус орлого	72,746,001.00	294,854,660.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,019,400.00	8,635,453.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,019,400.00	1,375,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,864,546.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,395,007.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,586,563,100.00	1,480,222,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,345,406,700.00	1,282,051,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,345,406,700.00	1,282,051,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	241,156,400.00	198,171,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,156,400.00	198,171,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,534,641,028.66	1,711,245,936.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,534,641,028.66	1,711,245,936.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,464,194,671.86	1,676,175,436.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,924,612.00	1,107,267,172.00
210101	Үндсэн цалин	578,218,553.00	640,920,061.00
210102	Нэмэгдэл	287,073,849.00	364,556,492.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	32,070,000.00
210104	Урамшуулал	65,632,210.00	69,720,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,043,374.42	138,475,741.04
210201	Тэтгэврийн даатгал	79,902,800.00	95,050,892.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,400,300.00	11,115,098.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,700,200.00	5,508,803.17
210204	Ажилгүйдлийн даатгал	4,620,648.93	5,306,703.01
210205	Эрүүл мэндийн даатгал	18,419,425.49	21,494,243.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,237,651.20	202,826,307.84
210301	Гэрэл, цахилгаан	9,732,119.81	11,247,565.74
210302	Түлш, халаалт	187,935,531.39	190,965,242.10
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	613,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,235,408.00	27,193,436.00
210401	Бичиг хэрэг	5,795,700.00	5,580,038.00
210402	Тээвэр, шатахуун	4,439,600.00	3,505,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,125,000.00	7,255,919.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	00.00	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,844,640.00	6,994,000.00
210408	Бараа материал акталсны зардал	13,030,468.00	3,827,579.00
2105	Нормативт зардал	35,162,977.00	39,047,432.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	173,115.00	200,740.00
210502	Хоол, хүнс	34,989,862.00	38,846,692.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,001,000.00	10,868,536.00
210604	Урсгал засвар	3,001,000.00	10,868,536.00
2107	Томилолт, зочны зардал	2,502,000.00	1,530,000.00
210702	Дотоод албан томилолт	2,502,000.00	1,530,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,754,471.60	7,884,285.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,607,710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	806,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,285,271.60	5,395,175.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,333,177.64	141,082,525.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,362,968.40	7,045,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	955,000.00	1,209,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,015,209.24	132,827,725.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,446,356.80	35,070,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,511,300.00	35,070,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,774,000.00	35,070,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,737,300.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,935,056.80	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,935,056.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	124,668,072.34	63,831,024.82
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	124,668,072.34	63,831,024.82

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,592,582,500.00	1,484,462,746.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,019,400.00	4,240,446.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,019,400.00	4,240,446.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,019,400.00	4,240,446.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,019,400.00	1,375,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,864,546.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,586,563,100.00	1,480,222,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,345,406,700.00	1,282,051,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,345,406,700.00	1,282,051,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	241,156,400.00	198,171,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,156,400.00	198,171,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,398,116,682.42	1,590,796,233.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,398,116,682.42	1,590,796,233.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,327,670,325.62	1,556,426,833.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,924,612.00	1,108,145,702.00
210101	Үндсэн цалин	578,218,553.00	641,798,591.00
210102	Нэмэгдэл	287,073,849.00	364,556,492.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	32,070,000.00
210104	Урамшуулал	65,632,210.00	69,720,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,043,374.42	138,475,741.04
210201	Тэтгэврийн даатгал	79,902,800.00	95,050,892.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,400,300.00	11,115,098.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,700,200.00	5,508,803.17
210204	Ажилгүйдлийн даатгал	4,620,648.93	5,306,703.01

210205	Эрүүл мэндийн даатгал	18,419,425.49	21,494,243.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,221,343.20	195,471,300.00
210301	Гэрэл, цахилгаан	9,732,119.81	11,247,565.74
210302	Түлш, халаалт	191,255,531.39	182,950,234.26
210303	Цэвэр, бохир ус	1,233,692.00	1,273,500.00
2105	Нормативт зардал	33,546,148.00	39,416,450.00
210502	Хоол, хүнс	33,546,148.00	39,416,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,700,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,134,773.00	13,823,694.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,959,600.00	1,332,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,175,173.00	12,491,094.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,800,075.00	58,393,946.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,626,675.00	53,054,046.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,173,400.00	5,339,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,446,356.80	34,369,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,511,300.00	34,369,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,774,000.00	34,369,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,737,300.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,935,056.80	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,935,056.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	194,465,817.58	-106,333,487.81
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,989,500.00	208,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,989,500.00	208,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,989,500.00	208,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,989,500.00	208,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,989,500.00	-208,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	165,476,317.58	-106,541,487.81
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,187,680.01	203,663,997.59
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	203,663,997.59	97,122,509.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	797,994,547.50	122,990,468.00	-182,257,627.67	00.00	738,727,387.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	797,994,547.50	122,990,468.00	-182,257,627.67	00.00	738,727,387.83

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,950,575.21	00.00	-2,950,575.21
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	930,072,547.50	414,546,742.48	2,688,373,618.56	00.00	4,032,992,908.54
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	930,072,547.50	414,546,742.48	2,688,373,618.56	00.00	4,032,992,908.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	930,072,547.50	414,546,742.48	2,688,373,618.56	00.00	4,032,992,908.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	63,831,024.82	00.00	63,831,024.82
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	930,072,547.50	414,546,742.48	2,752,204,643.38	00.00	4,096,823,933.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,514,031,600.00	1,392,832,933.81	121,198,666.19	92.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,031,600.00	1,392,832,933.81	121,198,666.19	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,477,712,200.00	1,358,463,533.81	119,248,666.19	91.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,187,668,500.00	1,108,145,702.00	79,522,798.00	93.3
210101	Үндсэн цалин	689,020,800.00	641,798,591.00	47,222,209.00	93.1
210102	Нэмэгдэл	437,095,500.00	364,556,492.00	72,539,008.00	83.4

210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	32,070,000.00	-32,070,000.00	0.0
210104	Урамшуулал	61,552,200.00	69,720,619.00	-8,168,419.00	113.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,458,400.00	138,475,741.04	9,982,658.96	93.3
210201	Тэтгэврийн даатгал	100,951,800.00	95,050,892.90	5,900,907.10	94.2
210202	Тэтгэмжийн даатгал	11,876,600.00	11,115,098.23	761,501.77	93.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,300.00	5,508,803.17	429,496.83	92.8
210204	Ажилгүйдлийн даатгал	5,938,300.00	5,306,703.01	631,596.99	89.4
210205	Эрүүл мэндийн даатгал	23,753,400.00	21,494,243.73	2,259,156.27	90.5
2105	Нормативт зардал	53,497,000.00	39,416,450.00	14,080,550.00	73.7
210502	Хоол, хүнс	53,497,000.00	39,416,450.00	14,080,550.00	73.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,201,200.00	13,823,694.77	1,377,505.23	90.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,332,600.00	1,332,600.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,868,600.00	12,491,094.77	1,377,505.23	90.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72887100.00	58601946.00	14,285,154.00	80.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,510,000.00	53,262,046.00	14,247,954.00	78.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,377,100.00	5,339,900.00	37,200.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36319400.00	34369400.00	1,950,000.00	94.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,319,400.00	34,369,400.00	1,950,000.00	94.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,319,400.00	34,369,400.00	1,950,000.00	94.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,514,031,600.00	1,286,291,446.00	227,740,154.00	85.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,294,594,000.00	1,282,051,000.00	12,543,000.00	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,294,594,000.00	1,282,051,000.00	12,543,000.00	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	219,437,600.00	4,240,446.00	215,197,154.00	1.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,332,600.00	1,375,900.00	-43,300.00	103.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,530,000.00	2,864,546.00	12,665,454.00	18.4
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	202,575,000.00	00.00	202,575,000.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	203,663,997.59	203,663,997.59	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	97,122,509.78	-97,122,509.78	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	39.00	0.00	0.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	0.00	0.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.00	0.0

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	198,171,300.00	198,171,300.00	-
УРСГАЛ ЗАРДАЛ	198,171,300.00	198,171,300.00	-
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,171,300.00	198,171,300.00	-
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,171,300.00	198,171,300.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,471,300.00	195,471,300.00	-
Гэрэл, цахилгаан	20,980,500.00	11,247,565.74	9,732,934.26
Түлш, халаалт	169,243,800.00	182,950,234.26	- 13,706,434.26
Цэвэр, бохир ус	5,247,000.00	1,273,500.00	3,973,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,700,000.00	2,700,000.00	-
Урсгал засвар	2,700,000.00	2,700,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	198,171,300.00	198,171,300.00	-
Орон нутгийн төсвөөс	198,171,300.00	198,171,300.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь Эрүүл чийрэг, амьдрах чадвартай, зөв хандлагатай иргэн төлөвшүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна. Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulous" программ хангамж ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,237.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	203,663.9	97,122.5	-106,541.4
Авлага	0.0	878.5	878.5
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	107,916.4	129,641.3	21,724.9
Үндсэн хөрөнгө	3,748,707.0	3,869,882.7	121,175.7

Нийт хөрөнгө	4,060,287.4	4,097,525.0	37,237.6
Өр төлбөр	27,294.5	701.1	-26,593.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,032,992.9	4,096,823.9	63,831.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,060,287.4	4,097,525.0	37,237.6

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 97,122.5 болж 106,541.4 мянган төгрөгөөр буурсан нь санхүүжилт буурч, төсвийн хэмнэлт горимд шилжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 878.5 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчийн цалинтай холбоотой үүссэн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 129,641.3 мянган төгрөг болж 21,724.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан 26,173.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,869,882.7 мянган төгрөг болж 121,175.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 208.0 мянга, хандив болон үнэ төлбөргүй хүлээн авсан 254,001.3 мянган төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд бүртгэж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,096,823.9 мянган төгрөг болж 63,831.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,944,114.07 мянга, орон нутгийн төсвөөс 397,801.2 мянга, нийт зарлагыг 2,341,915,27 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг зардлыг 662,063.07 мянган бууруулж 2025 онд улсын төсвөөс 1,282,051.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,282,051.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,375.9 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,864.5 мянга, нийт 1,286,291.4 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,392,832.9 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 97,122.5 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Ерөнхий боловсрол, байр ашиглалт 80226	1,437.5	1,437.5	0	100%
2	Ерөнхий боловсрол, хүүхэд хамгаалал 80233	1,797.0	1593.2	101.9	88,65%
3	Ерөнхий боловсрол, сургалт семинар 80312	920.9	920.9	1.4	100%
4	Ерөнхий боловсрол, эрүүл мэндийг дэмжих 81605	1,813.0	1,710.0	103.0	94.3%

5	Ерөнхий боловсрол, үдийн цай хөтөлбөр 81801	36,319.4	34,369.4	0	100%
6	Ерөнхий боловсрол, дотоор байрны үйлчилгээ 81806	270,098.7	209,218.80	48,062.32	81,91%
7	Ерөнхий боловсрол, нөхөн хангалтын зардал 81816	27,294.5	27,294.5	3.0	100%
8	Ерөнхий боловсрол, багш ажилтны мэргэжил дээшлүүлэх 81823	5,154.1	3,981.4	854.7	82,3%
9	Ерөнхий боловсрол, Бичиг үсгийн боловсрол 81827	8,126.4	2,376.2	5,735.84	28,62%
10	Ерөнхий боловсролын стандарт 81834	1,088,025.2	1,062,368.43	25,656.77	97,62%
11	Ерөнхий боловсрол, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 81835	47,580.8	36,102.18	15,222.04	68,0%
12	Ерөнхий боловсрол, сургалтын орчин сайжруулах 81844	18,133.0	6,394.54	0	100%
13	Ерөнхий боловсрол, сурах бичиг түрээсийн ном 81848	1,332.6	1,332.6	43.3	100%
14	Ерөнхий боловсрол, нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх 81875	4,968.5	3,733.26	1,235.23	75,13%
15	Ерөнхий боловсрол, дээд шатны төсвөөс хуваарилсан 83603	1,030.0	0	103.0	0%
16	Ерөнхий боловсрол, төрийн өмчийн барилын тогтмол зардал 80111	198,171.3	198,171.3	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль орон нутгийн төсвөөс 198,171.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан 11,247.6 мянга, түлш халаалт 182,950.2 мянга, цэвэр, бохир ус 1,273.5 мянга, урсгал засвар 2,700.0 мянга, нийт 198,171.3 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд харьцуулалтын аргаар багцын тендер зарлаж дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардалд 39,416.4 мянган төгрөг, үдийн хоолны материалын зардалд 34,369.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,534,641.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,346.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,277.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,706,850.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 17,068.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 13,654.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцорч оруулсан 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгч биелэлтийг Түргэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах үзэх чухал асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,495.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

- 1.1. Төрийн үйлчилгээний албан хаагчид 230 илүү цаг ажилласны нэмэгдэл хөлс 1,495.7 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3-д "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- 1.2. Цаашид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгохдоо журамд заасан хувь хэмжээг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн	1	1,495.7					1	1,495.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Ч.МӨНХТОГТОХ/

2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Түргэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудит
 Байгууллагын нэр: Увс аймаг дахь Төрийн аудитын газар
 Тайлант хугацаа: 2025 он

№	Ажил гүйцээний анги, дансны үлдэгдэл тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдвэр	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	6	7	8	9	10
1	Цалингийн зардал	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журамд заасан хэмжээнээс илүү олгосон	1,495.7	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Хариу тайлбар шаардлагагүй	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	С.Батсүх Г.Буддарь
		Нийт дүн	1,495.7						

Бэлтгэсэн:
Ахлах аудитор

Хянасан:
Аудитын менежер

Дарга, тэрүүлэх аудитор

Ч.Мөнхтогтох

М.Бат-Амгалан

М.Батсүүрб

Танилцаж зөвшөөрсөн:

Захирал

Нягтлан бодогч

